



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/789

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг төв цэнгэлдэхийн 2 дугаар гудамж 200 тоотод байрлах 50114м² газрыг Арвайхээр хотын Захирагчийн албандаа наадмын талбайн зориулалтаар, Намнансүрэнгийн гудамж наадмын талбайн зүүн талд 2464м² газрыг аймгийн Биеийн тамир, спортын газар (РД9044086)-т биеийн тамир, спортын байгууллагын зориулалтаар, Пүрэвдоржийн 3 дугаар гудамж 101 тоотод байрлах 1950м² газрыг Арвайхээр сумын гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын Мэргэд сургууль (9047662)-д боловсролын байгууллагын зориулалтаар тус тус 40 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 168 дугаар захирамжийн Арвайхээр хотын Захирагчийн албандаа холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101736

D:My Doc. Zahiramj. Zasag darga